


ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/66/НА-СТА-ТЗШ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Мөрөн сум 2024 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Давааням Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Отгонбаяр Утас: 89306788 Цахим хаяг: munkh-orgill@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

Аудитын дүгнэлт.....	4
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал.....	3
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....</b>	<b>13</b>
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН.....</b>	<b>17</b>
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>19</b>
5.2 Зөвлөмж .....	19
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>21</b>

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.25 № 01/73  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ  
СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА  
Ж.АМАРТҮВШИН ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Жаргалант сумын засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь самар бэлтгэх эрхийн дуудлага худалдаанаас 238,081.6 мянган төгрөгийн нэмэлт орлого олж, эрхийн дуудлага худалдаанд шалгараагүй оролцогчид 99,101.6 мянган төгрөг буцаан төлсөн, Байгаль орчин уур амьсгалын санд 69,565.0 мянган төгрөг шилжүүлж, орон нутгийн төсөвт 69,415.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэлтэй газар эзэмших эрхийг, газрын бичиг баримттай тулган шалгахад газар эзэмших эрхийн гэрчилгээ аваагүй байна.

#### Бусад асуудлын хэсэг

Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын дарга нь 2023 онд 1 зорилго 6 зорилтын хүрээнд 79 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулж, 90.2 хувьтай дүгнүүлсэн байна.

6724040119

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	125,168,731.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	193,099,314.32	192,653,514.32
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,295,786,310.82</b>	<b>3,420,955,042.75</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>893,670,853.20</b>	<b>1,552,988,040.80</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>81,165,298.00</b>	<b>269,108,342.80</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>81,165,298.00</b>	<b>269,108,342.80</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	81,165,298.00	269,108,342.80
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	81,165,298.00	269,108,342.80
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>812,505,555.20</b>	<b>1,283,879,698.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>55,679,355.20</b>	<b>297,776,098.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,246,000.00	3,696,978.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,433,355.20	293,079,120.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>756,826,200.00</b>	<b>986,103,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	756,826,200.00	986,103,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>963,072,970.15</b>	<b>1,426,598,225.38</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>813,662,970.15</b>	<b>1,426,598,225.38</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>696,307,664.47</b>	<b>1,146,506,561.05</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>268,471,271.69</b>	<b>427,150,132.69</b>
210101	Үндсэн цалин	223,223,649.69	306,769,872.49
210102	Нэмэгдэл	45,247,622.00	88,571,367.95
210104	Урамшуулал	00.00	34,187,128.44
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>33,248,748.21</b>	<b>52,333,689.48</b>
210201	Тэтгэврийн даатгал	23,126,851.33	36,509,907.11
210202	Тэтгэмжийн даатгал	2,684,713.22	4,295,283.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,982,468.38	3,436,226.91
210204	Ажилгүйдлийн даатгал	495,883.84	859,056.77
210205	Эрүүл мэндийн даатгал	4,958,831.44	8,590,574.52
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>37,225,776.00</b>	<b>44,908,560.50</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,414,175.00	12,789,712.50
210302	Түлш, халаалт	28,811,601.00	32,118,848.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>56,312,244.00</b>	<b>67,397,961.00</b>
210401	Бичиг хэрэг	4,132,370.00	7,368,000.00
210402	Тээвэр, шатахуун	34,785,174.00	44,476,831.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,441,000.00	3,320,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,953,700.00	3,522,200.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	5,847,730.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>725,000.00</b>	<b>00.00</b>

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	725,000.00	00.00
210502	Хоол, хүнс	00.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,000,000.00</b>	<b>53,124,660.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00
210604	Урсгал засвар	15,000,000.00	53,124,660.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,751,000.00</b>	<b>5,200,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,751,000.00	5,200,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>78,999,573.00</b>	<b>243,977,576.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	77,138,580.00	240,917,851.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	99,000.00	1,674,236.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	97,474.00	111,474.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	88,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>203,574,051.57</b>	<b>248,678,385.76</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,348,145.00	30,509,180.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	176,225,906.57	218,169,205.76
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>117,355,305.68</b>	<b>280,091,664.33</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>41,448,774.00</b>	<b>25,263,600.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	23,098,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,669,974.00	2,165,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>75,906,531.68</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	254,828,064.33
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-69,402,116.95</b>	<b>126,389,815.42</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>1,221,083.49</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,221,083.49
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-1,221,083.49</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-69,402,116.95</b>	<b>125,168,731.93</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>812,505,555.20</b>	<b>1,283,879,698.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>812,505,555.20</b>	<b>1,283,879,698.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>55,679,355.20</b>	<b>297,776,098.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,246,000.00	3,696,978.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,433,355.20	293,079,120.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>756,826,200.00</b>	<b>986,103,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	756,826,200.00	986,103,600.00

2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>637,043,855.20</b>	<b>1,255,894,698.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>637,043,855.20</b>	<b>1,255,894,698.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>519,058,523.52</b>	<b>973,038,533.67</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>274,376,453.10</b>	<b>427,150,132.69</b>
210101	Үндсэн цалин	224,313,724.50	306,769,872.49
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>32,816,058.42</b>	<b>52,333,689.48</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,622,266.93	35,389,811.46
210202	Тэтгэмжийн даатгал	2,661,357.90	4,235,619.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,128,946.37	3,388,915.60
210204	Ажилгүйдлийн даатгал	491,352.37	847,399.86
210205	Эрүүл мэндийн даатгал	4,912,134.85	8,471,943.17
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>36,000,000.00</b>	<b>45,408,560.50</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,414,175.00	12,789,712.50
210302	Түлш, халаалт	27,585,825.00	32,118,848.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	500,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>53,979,400.00</b>	<b>53,572,506.00</b>
210401	Бичиг хэрэг	3,913,000.00	6,169,000.00
210402	Тээвэр, шатахуун	34,033,100.00	35,700,806.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,441,000.00	3,320,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,000,000.00	4,382,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,592,300.00	4,000,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,000,000.00</b>	<b>51,057,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00
210604	Урсгал засвар	20,000,000.00	51,057,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,751,000.00</b>	<b>5,200,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,751,000.00	5,200,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>68,941,493.00</b>	<b>290,757,145.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	67,080,500.00	287,727,260.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	99,000.00	1,674,236.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	97,474.00	111,474.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	80,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	1,000,000.00
210807	Газрын төлбөр	784,519.00	156,175.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	00.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>30,194,119.00</b>	<b>47,559,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,194,119.00	47,559,500.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>117,985,331.68</b>	<b>282,856,164.33</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>42,078,800.00</b>	<b>28,028,100.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	23,098,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,300,000.00	4,930,000.00

2134	Орон нутгийн төсвийн өрөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	75,906,531.68	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,906,531.68	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	175,461,700.00	27,985,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	175,461,700.00	27,985,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	175,461,700.00	27,985,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	175,461,700.00	27,985,000.00
223001	Бусад хөрөнгө	149,410,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,051,700.00	27,985,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-175,461,700.00	-27,985,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,010,256,554.27	196,086,044.32	-384,155,049.57	2,822,187,549.02
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,010,256,554.27	196,086,044.32	-381,168,319.57	2,825,174,279.02
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	543,000,878.75	543,000,878.75
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,010,256,554.27	193,099,314.32	92,430,442.23	3,295,786,310.82
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,010,256,554.27	193,099,314.32	92,430,442.23	3,295,786,310.82
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	445,800.00	445,800.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,010,256,554.27	193,099,314.32	92,876,242.23	3,296,232,110.82
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-445,800.00	00.00	-445,800.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	125,168,731.93	125,168,731.93
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,010,256,554.27	192,653,514.32	218,044,974.16	3,420,955,042.75

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	975,233,600.00	809,351,973.67	165,881,626.33	82.99
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	975,233,600.00	809,351,973.67	165,881,626.33	82.99
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	950,553,500.00	784,671,873.67	165,881,626.33	82.55
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	440,072,900.00	427,150,132.69	12,922,767.31	97.06
210101	Үндсэн цалин	351,882,200.00	306,769,872.49	45,112,327.51	87.18
210102	Нэмэгдэл	88,190,700.00	88,571,367.95	-380,667.95	100.43
210104	Урамшуулал	00.00	31,808,892.25	-31,808,892.25	
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	58,593,400.00	52,333,689.48	6,259,710.52	89.32
210201	Тэтгэврийн даатгал	40,143,500.00	35,389,811.46	4,753,688.54	88.16
210202	Тэтгэмжийн даатгал	4,612,400.00	4,235,619.39	376,780.61	91.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,689,900.00	3,388,915.60	300,984.40	91.84
210204	Ажилгүйдлийн даатгал	922,600.00	847,399.86	75,200.14	91.85
210205	Эрүүл мэндийн даатгал	9,225,000.00	8,471,943.17	753,056.83	91.84
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	64,700,000.00	45,408,560.50	19,291,439.50	70.18
210301	Гэрэл, цахилгаан	8,200,000.00	12,789,712.50	-4,589,712.50	155.97
210302	Түлш, халаалт	56,000,000.00	32,118,848.00	23,881,152.00	57.36
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	500,000.00	0.00	100.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	53,286,000.00	51,586,742.00	1,699,258.00	96.81
210401	Бичиг хэрэг	5,800,000.00	5,800,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	35,475,000.00	34,084,042.00	1,390,958.00	96.08
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,511,000.00	3,320,000.00	1,191,000.00	73.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,500,000.00	4,382,700.00	-882,700.00	125.22
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	42,500,000.00	42,500,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	42,500,000.00	42,500,000.00	0.00	100.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	265,815,200.00	142,756,249.00	123,058,951.00	53.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	262,115,200.00	140,200,600.00	121,914,600.00	53.49
210803	Даатгалын үйлчилгээ	1,200,000.00	1,200,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	205,000.00	111,474.00	93,526.00	54.38
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	160,000.00	88,000.00	72,000.00	55.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	1,135,000.00	156,175.00	978,825.00	13.76
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>21086000.00</b>	<b>18436500.00</b>	<b>2,649,500.00</b>	<b>87.43</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,086,000.00	18,436,500.00	2,649,500.00	87.43
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24680100.00</b>	<b>24680100.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,680,100.00</b>	<b>24,680,100.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,098,100.00	23,098,100.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,582,000.00	1,582,000.00	0.00	100.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>10,870,000.00</b>	<b>00.00</b>	<b>10,870,000.00</b>	<b>0.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>10,870,000.00</b>	<b>00.00</b>	<b>10,870,000.00</b>	<b>0.00</b>
223001	Бусад хөрөнгө	10,870,000.00	00.00	10,870,000.00	0.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	00.00	00.00	0.00	0.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>986,103,600.00</b>	<b>809,351,973.67</b>	<b>176,751,626.33</b>	<b>82.08</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>986,103,600.00</b>	<b>809,351,973.67</b>	<b>176,751,626.33</b>	<b>82.08</b>
132001	Орон нутгийн төсвөөс	986,103,600.00	809,351,973.67	176,751,626.33	82.08
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>01.00</b>	<b>01.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>28.00</b>	<b>28.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00	0.00	100.00
620004	Гэрээт ажилтан	04.00	04.00	0.00	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>219,699,660.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>219,699,660.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>216,351,660.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,985,764.00</b>
210401	Бичиг хэрэг	369,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,616,764.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,557,000.00</b>
210604	Урсгал засвар	8,557,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>700,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	700,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>175,985,896.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	175,511,660.00
210803	Даатгалын үйлчилгээ	474,236.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>29,123,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,123,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,348,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,348,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,348,000.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	

230001	Эргэж төлөгдөх зээл	
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>297,776,098.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>297,776,098.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,696,978.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	293,079,120.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлд заасны дагуу харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, төсөл хөтөлбөр зохион байгуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах чиг үүрэг бүхий Жаргалант сумын Засаг даргын харьяа байгууллага юм.

Тус газар нь тайлант онд “Иргэдэд ойр тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн уян хатан, идэвхтэй, санаачилгатай төрийн албаны стандарт ёс зүйг чанд сахидаг, өндөр мэргэжлийн чадавх бүхий цомхон, мэргэшсэн чадварлаг, эцсийн үр дүн нь бүтээгдэхүүнд суурилсан хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж, нутгийн захиргааны үр дүнтэй хэвийн үйл ажиллагааг хангаж, хөгжил дэвшилд хүрч хөгжлийн үзүүлэлтийн түвшнээр тэргүүлэн ИДЭР БҮС-ийн хөгжлийн тулгуур төв болох” зорилгын хүрээнд 6 зорилт, 79 арга хэмжээг 90.2 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ЗДТГ нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомжид өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль...

Харин байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн ерөнхий бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Жаргалант сумын ЗДТГ-ын үйл ажиллагаанд дотоод хяналтын хэрэгжүүлэх зөвлөлийг ЗДТГ-ын даргын 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/04 дугаар тушаалаар байгуулсан байна.

Тус зөвлөл нь 2023 онд дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн алба, Байгаль орчин тогтвортой хөгжлийн тасгийн шатахуун, бичиг хэргийн зардлын зарцуулалт, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, тооллого тооцоо, ашиглалт хамгаалалтад 1 удаа хяналт хэрэгжүүлж, үр дүнг хамт олны хуралд танилцуулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үнэллээ.

Тус байгууллагын санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод аудитыг Хөвсгөл аймгийн Санхүү хяналт аудитын алба гүйцэтгэдэг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хөвсгөл аймгийн засаг даргын 2019 оны А/375 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг удирдлага болгон ажиллаж байна.

Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэнтэй холбоотой бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах шаардлага тулгараад байна. Санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 125,168.7 мянган төгрөгөөр буюу 3.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			0
Авлага	3,735.6		-3,735.6
Бараа материал	97,584.5	189,957.2	92,372.7
Үндсэн хөрөнгө	3,181,804.2	3,230,045.3	2,740.5

Нийт хөрөнгө	3,295,786.3	3,420,955.0	125,168.7
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,010,256.6	3,010,256.6	0.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,295,786.3	3,420,955.0	125,168.7

Дээрх хүснэгтээс харахад:

- Авлага данс өмнөх оноос 3,735.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд татварын байгууллагад илүү шилжүүлсэн мөнгийг суутган тооцсонтой холбоотой байна.
- Бараа материал данс өмнөх оноос 92,372.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Харцахт эрчим ХХК-аас 26,000.0 мянган төгрөгийн мал үнэ төлбөргүй хүлээн авсан, Залуу төгөл ХХК-аас тусгай зориулалттай материал болох хортон шавжтай тэмцэх 31,971.8 мянган төгрөгийн багаж болон түүхий эд материал худалдан авсан, Түмний хүрд ХХК-аас 8,000.0 мянган төгрөгөөр чацарганын мод болон хамгаалах хашаа барих шон худалдан авсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Жаргалант сумын ЗДТГ-ын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг санхүүгийн дэмжлэгээс 78,944.6 мянган төгрөг, орон нутгийн давсан орлогоос 16,400.0 мянган төгрөг, сумын орлогоос 553,724.1 мянган төгрөг, дансны үлдэгдлээс 42,256.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 691,324.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн жаргалант сумын ИТХ-ын ээлжит хуралдаанаар батлуулсан

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 986,103.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 176,751.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 809,351.9 сая төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/Д	Хөтөлбөр	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
					Зөрүү	Биелэлт
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	80101- Үндсэн үйл ажиллагаа	601,197.6	552,415.7	48,781.8	97.0
2		80106- Баг хорооны үйл ажиллагааны зардал	92,496.7	87,040.0	5,456.0	91.2
3		80305- Биеийн тамирын уралдаан тэмцээн	3,000.0	3,000.0	0	100.0
4		80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	24,680.1	24,680.1	0	100.0
5		81102- Орон нутгийн нөөц хөрөнгө	25,870.0	6,355.9	19,514.1	90.0
6		82801- Улсын их баяр наадам	10,000.0	10,000.0	0	100.0
7	70503-Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	80918- Бусад	10,870.0		0	0

8	71413- Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	81701- Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	217,989.2	125,860.2	92,129.0	83.5
		<b>Дүн</b>	986,103.6	809,351.9	176,751.7	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ЗДТГ нь тайлант онд 297,776.1 мянган төгрөгийн дараах нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого /самар олборлох эрхийн дуудлага худалдаа зохион байгуулах, дэнчингийн/ 238,081.6 мянган төгрөг,
- Дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан 3,697.0 мянган төгрөг
- ковшийн түрээс, ухаалаг худгийн орлого, бохирын зөөврийн орлого 55,733.0 мянган төгрөг тус тус хүлээн авч, зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн эх үүсвэр, зарцуулалт нь холбогдох хууль журамд нийцсэн байна гэж дүгнэлээ.

Дээрх нэмэлт санхүүжилтийг зарцуулсан тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2023 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ЗДТГ нь тайлант онд 5 нэр төрлийн 116,165.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй бараа ажил үйлчилгээг худалдан авсан байна.

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл	Арга	Батлагдсан төсөвт өртөг /мян. төг/	Гэрээний дүн	Гүйцэтгэгчийн нэр
1	Гэрэл цахилгааны зардал	ХТШ	8,200.0	8,200.0	ЭБЦСТӨК ХХК
2	Түлш халаалтын зардал	ХТШ	35,000.0	32,118.8	ЭНХ НОМИН УНДАРГА ХХК
3	Тээвэр шатахуун	ХТШ	27,995.0	28,775.0	ЭНХ НОМИН УНДАРГА ХХК
4	Урсгал засварын зардал	ХА	35,000.0	34,970.1	Дөрвөлжин Дэнж ХХК
5	Бусад Нийтлэг АУТХураамж	ШХА	10,000.0	10,000.0	Агнуурын менежментийн тех төв ТББ
	<b>Дүн</b>		116,195.0	114,063.9	

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3-т “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл” гэж заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хамт ирүүлсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн сахилга батыг сайжруулах, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Отгонбаяр гүйцэтгэж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Б.Давааням, чанарын хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 3/69 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 963,072.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 19,261.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 15,409.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй асуудлууд илэрсэнгүй.

➤ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд авсан судалгааны үр дүн:

1. Тус байгууллага нь албан хэрэгцээнд 2, хогийн цэг түрэх, байгалийн гамшигт үзэгдэл зам харгуй боогдсон түрж нээх зориулалт бүхий 1, бохир соруулах зориулалт бүхий 1, нийт 4 автомашин ашиглаж байгаа бөгөөд дуудлагын автомашин ашиглаагүй байна.
2. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Жаргалант сумын засаг дарга нь 1 орлогч дарга томилон ажиллуулж, цалингийн зардалд 22,621.7 мянган төгрөг зарцуулсан байна.
3. Мөн цахим дэлгүүрээс худалдан авалт хийх туршлага байхгүй гэсэн шалтгаанаар тайлант онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ЗДТГ-ын 2023 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн шалгахад алдаа зөрчилтэй асуудал илэрсэнгүй.

- Тендерт шалгарсан болон шалгараагүй талаарх товч мэдээлэл
- Цалингийн зардлаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 101 нэр төрлийн 110 ширхэг 250,008.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Үлдэх өртөггүй болсон хөрөнгүүдийг данснаас хасах, дахин үнэлэх ажлыг зохион байгуулж ажиллаагүй байна. Энэ нь УСНББОУС-17 Параграф 49, УСНББОУС-31 Параграф 78, Засгийн газрын 2006 оны 388 дугаар тушаалын нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.41-т "Биет хөрөнгийн дансны үнэ бодит үнээсээ материаллаг хэмжээний зөрүүтэй байх нөхцөлд хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ" гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн*

2. Байгууллагын газар эзэмших гэрчилгээг үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад газар эзэмших эрхийн гэрчилгээ аваагүй байна. Үүнд: Хүнсний битүү зах, эрчим хүчний барилга, Баярын талбай, зоорь, гүн өрмийн худаг, Сумын төвийн ухаалаг худаг, конторын барилга, орон сууц, хүрэн агуулах, тэжээлийн агуулах, халуун усны барилга, буудал, хөшигт модны худаг зэрэг хөрөнгийн эзэмшил газрыг кадастрын зураг болон газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээгүй байна.

Энэ нь Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т "Газрыг энэ хуульд заасан зориулалт, хугацаа, болзолтойгоор гэрээний үндсэн дээр зөвхөн эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлнэ.", 27.2-т "Газар эзэмших эрхийн гэрчилгээг зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгоно.", 27.3-т "Нэгж талбар бүр эрхийн гэрчилгээтэй байна." 34.10-т "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ нь тухайн газар дээрх тэдгээрийн үл хөдлөх хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэх үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн.*

3. Биет бус хөрөнгийн бүртгэлд Засаг даргын 2018 оны А/89 захирамжаар 20 газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон боловч НББ-д бүртгэхдээ нийт дүнгээр тусгасан байна. Энэ нь УСНББОУС 12-ын параграф 16 "Бараа материалыг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд тэдгээрийн өртгийг тухайн олж эзэмшсэн өдрөөрх бодит үнэ цэнээр хэмжинэ" гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн.*

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 2,703.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 741,560.1 мянган төгрөгийн зөрчил таслан зогсоох 2 албан шаардлага хүргүүлсэн нь бүрэн биелсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	2,703.6	2	2,703.6	100%
Албан шаардлага	2	741,560.1	2	741,560.1	100%
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>744,263.7</b>	<b>4</b>	<b>744,263.7</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 0 мянган төгрөгийн 3 зөрчил<sup>1</sup> илэрснээс 3 зөвлөмжийг Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

#### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

*Илрүүлэлт* Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 101 нэр төрлийн 110 ширхэг 250,008.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Үлдэх өртөггүй болсон хөрөнгүүдийг данснаас хасах, дахин үнэлэх ажлыг зохион байгуулж ажиллаагүй байна. Энэ нь УСНББОУС-17 Параграф 49, УСНББОУС-31 Параграф 78, Засгийн газрын 2006 оны 388 дугаар тушаалын нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.41-т "Биет хөрөнгийн дансны үнэ бодит үнээсээ материаллаг хэмжээний зөрүүтэй байх нөхцөлд хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ" гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Байгууллагын газар эзэмших гэрчилгээг үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган шалгахад газар эзэмших эрхийн гэрчилгээ аваагүй байна. Үүнд: Хүнсний битүү зах, эрчим хүчний барилга, Баярын талбай, зоорь, гүн өрмийн худаг, Сумын төвийн ухаалаг худаг, конторын барилга, орон сууц, хүрэн агуулах, тэжээлийн агуулах, халуун усны барилга, буудал, хөшигт модны худаг зэрэг хөрөнгийн эзэмшил газрыг кадастрын зураг болон газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээгүй байна.

Энэ нь Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т "Газрыг энэ хуульд заасан зориулалт, хугацаа, болзолтойгоор гэрээний үндсэн дээр зөвхөн эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлнэ.", 27.2-т "Газар эзэмших эрхийн гэрчилгээг зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгоно.", 27.3-т "Нэгж талбар бүр эрхийн гэрчилгээтэй байна." 34.10-т "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ нь тухайн газар дээрх тэдгээрийн үл хөдлөх хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэх үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн байрших газрыг баталгаажуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ авах

Илрүүлэлт: Биет бус хөрөнгийн бүртгэлд Засаг даргын 2018 оны А/89 захирамжаар 20 газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон боловч НББ-д бүртгэхдээ нийт дүнгээр тусгасан байна. Энэ нь УСНББОУС 12-ын параграф 16 "Бараа материалыг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд тэдгээрийн өртгийг тухайн олж эзэмшсэн өдрөөрх бодит үнэ цэнээр хэмжинэ" гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын бүртгэлийг газрын гэрчилгээнд заасан хэмжээ болон үнэ цэнээр залруулан бүртгэх

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 үлдэгдэлтэй хөрөнгө	1	0.0					1	0.0
Газрын баримт бичиг дутуу	1	0.0					1	0.0
Газрын хэмжээг буруу бүртгэсэн	1	0.0					1	0.0
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>0.0</b>					<b>3</b>	<b>0.0</b>